

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТАЛААР
/шинэчилсэн найруулга/**

2020 он

ГАРЧИГ

Нэг. Оршил

Хоёр. Хуулийн агуулга

Гурав. Хуулийн бүтэц

Дөрөв. Хуулийн зарим зохицуулалтаас

Тав. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актууд

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТУХАЙ ХУУЛЬ**
/Шинэчилсэн найруулга/

Нэг.Оршил

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан бөгөөд 2020 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль нь 7 бүлэг, 51 зүйлтэй.

Хоёр: Хуулийн агуулга

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнийг томилж, чөлөөлж, огцруулдаг бүрэн эрх болон улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн бүтэц, хэмжээг өөрчлөн баталдаг байсныг халж, зарчмын томоохон өөрчлөлт оруулсан тул Улсын Их Хурлын хуулийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоох бүрэн эрхээ үр нөлөөтэй хэрэгжүүлдэг байхыг зорьжээ.

Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан билээ.

Энэхүү тогтоолын дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 7 бүлэг 50 зүйлтэй бөгөөд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой дараах харилцааг шинээр болон өөрчлөн найруулжээ. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлын зорилт, чиг үүрэг, Улсын Их Хурлын бие даасан байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг шинээр;

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх болон гишүүний тангаргийг өөрчлөн найруулж, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татахтай холбоотой зохицуулалтыг шинээр;

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох зохицуулалтыг боловсронгуй болгож;

4.Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн өөрчилж;

5.Улсын Их Хурлын даргыг сонгох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгож;

6.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хуулийг эцэслэн батлах, санал хураалт явуулах зарчмыг шинэчилж;

7.Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг хянан шалгаж, тайлан гаргах, түр хорооноос гаргасан тайлан шуухэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчилж;

8.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн зохицуулалтыг нарийвчлан тусгаж, сонгуулийн дараах эвслийн бүлгийн зохицуулалтыг шинээр;

9.Хууль тогтоох, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийн үр нөлөөг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрх болон хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 37, 39 дүгээр зүйлийг боловсронгуй болгож шинэчлэн найруулж, улмаар Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа албан тушаалтанд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэг хүлээлгэж, уг үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтан Улсын Их Хуралд санаатайгаар худал мэдээлэл өгсөн нь парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзэж түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр;

10.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг төслийн 38 дугаар зүйлээр тодорхойлж;

11.Улсын Их Хурлын ээлжит чуулганы ургэлжлэх хугацааг 75-аас доошгүй ажлын өдөр болгож өөрчилсөнтэй холбогдуулан намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 01-ний өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр хуралдаж байхаар;

12.Улсын Их Хурал нь анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы зохицуулалтыг боловсронгуй болгож;

13.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх үндэслэлийг хуульчилж;

14.Гишүүний үйл ажиллагаанд хориглох зүйлсэд олон улсын парламентын холбооноос гаргасан судалгаа, зөвлөмжид үндэслэн шинэ зохицуулалт нэмж;

15.Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх явцад нь шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, төсвийн дүн шинжилгээ хийж, өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар эрх зүйн дүн шинжилгээ, дүгнэлтээр гишүүдийг хангаж ажиллахаар;

16.2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нийт 17 удаа өөрчлөлт орж байсан бөгөөд Улсын Их Хурлын дарга, гишүүний бүрэн эрх болон бүлгийн үйл ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болох дэгийн зохицуулалт цөөнгүй байсан. Тэдгээр зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулахаар Улсын Их Хурлын тухай хуулиас хасч, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгэд оруулахаар тус тус зохицуулсан.

Эдгээр өөрчлөлттэй холбоотойгоор хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт бүрэн өөрчлөгдсөн бөгөөд эдгээр өөрчлөлт нь хуулийн нийт заалтын 50 хувиас илүү гарч байгаа нь хуулийн төслийг шинэчлэн найруулах үндэслэл болсон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн холбогдох зохицуулалтад нийцүүлэн хуулийг эцэслэн батлахдаа Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар батлах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, Улсын Их Хурлын болон гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох үндэслэлийг нарийвчлан тусгах зэрэг тодорхой өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгаснаар нийгэм, хууль зүйн эерэг дагавар үзүүлнэ гэж хууль санаачлагч үзжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, олон улсын чиг хандлагад тохируулан шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулсан учир цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд хэрэглэх, мэдлэг олгох зорилгоор энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хуулийг <https://legalinfo.mn/law/details/15441?lawid=15441> холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

ГУРАВ:ХУУЛИЙН БҮТЭЦ

№	Бүлэг	Зохицуулсан харилцаа
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үндсэн зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, зарчим 4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бие даасан байдал 5 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэр
2	Хоёрдугаар бүлэг Улсын Их Хурлын бүрэлдэхүүн	6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэлдэхүүн 7 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн 8 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх 9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх 10 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох 11 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь олонх ба цөөнх 12 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргыг сонгох 13 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа, түүнийг хугацаанаас өмнө чөлөөлөх, огцруулах 14 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх 15 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүнийг чиг үүрэг
3	Гуравдугаар бүлэг Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц	16 дугаар зүйл. Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр 17 дугаар зүйл. Анхдугаар чуулган 18 дугаар зүйл. Ээлжит чуулган 19 дүгээр зүйл. Ээлжит бус чуулган 20 дугаар зүйл. Онцгой чуулган 21 дүгээр зүйл. Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулган 22 дугаар зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам 23 дугаар зүйл. Байнгын хороо 24 дүгээр зүйл. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ 25 дугаар зүйл. Байнгын хорооны ажлын зохион байгуулалт 26 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүн


		27 дугаар зүйл. Байнгын хорооны даргын чиг үүрэг 28 дугаар зүйл. Дэд хороо 29 дүгээр зүйл. Түр хороо 30 дугаар зүйл. Хянан шалгах түр хороо 31 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ийн бүлэг 32 дугаар зүйл. Сонгуулийн дараах эвслийн бүлэг 33 дугаар зүйл. Бүлгийн эрх, үүрэг 34 дүгээр зүйл. Бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болох
4	Дөрөвдүгээр бүлэг Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа	35 дугаар зүйл. Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа 36 дугаар зүйл. Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох
5	Тавдугаар бүлэг Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх	37 дугаар зүйл. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх 38 дугаар зүйл. Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаар 39 дүгээр зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх
6	Зургаадугаар бүлэг Гишүүний бүрэн эрхийн баталгаа, төсөв, хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал, үйл ажиллагаанд нь хориглох зүйл	40 дүгээр зүйл. Гишүүний бүрэн эрхийн баталгаа 41 дүгээр зүйл. Гишүүний төсөв, цалин, бусад хангамж 42 дугаар зүйл. Гишүүн хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал 43 дугаар зүйл. Гишүүнд хориглох үйл ажиллагаа
7	Долдугаар бүлэг Улсын Их Хурал үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах	44 дүгээр зүйл. Тамгын газар, түүний эрхлэх ажил 45 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга 46 дугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх ажил 47 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын ажлын алба 48 дугаар зүйл. Улсын Их Хурлын төсөв 49 дүгээр зүйл. Улсын Их Хурлын төсвийг боловсруулах, хэлэлцүүлэх 50 дугаар зүйл. Улсын Их Хурлын төсвийг зарцуулах, гүйцэтгэлд тавих хяналт 51 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

ДӨРӨВ:ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТААС

Хуулийн зорилго /1 дүгээр зүйл/

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-ын бүрэн эрх, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдал, түүний баталгаа, Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмыг тогтооход оршино.

Улсын Их Хурлын үндсэн зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, зарчим /3 дугаар зүйл/



Улсын Их Хурлын бие даасан байдал /4 дүгээр зүйл/

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хэн ч халдаж үл болно.	
Улсын Их Хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно.	
Улсын Их Хурал санхүүгийн хувьд бие даасан, үйл ажиллагаагаа явуулахад хүрэлцэхүйц төсөвтэй байна.	
Улсын Их Хурал мэргэшсэн, чадварлаг ажлын албатай байх бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулах ордон, техник, тоног төхөөрөмжөөр хангагдана.	
Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурал батална.	
Улсын Их Хурлын бэлгэ тэмдэг, оноосон нэртэй адил утга, агуулгатай бэлгэ тэмдэг, нэршлийг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.	
Улсын Их Хурал Төрийн ордонд байрлана.	

Бүрэн эрхийнхээ хүрээнд

- Хууль

Бусад гаргах шийдвэр

- Тогтоол

2/Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг цахимаар болон “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд албан ёсоор бүрэн эхээр нь нийтэлнэ.

3/Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш **10 хоногийн дараа** хүчин төгөлдөр болно.

4/Тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/-ийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

5/Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ Улсын Их Хурлын цахим хуудсанд болон “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлсэн **албан ёсны эхийг баримтлах** бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

6/Энэ хуулийн 5.2-т заасан хэвлэн нийтлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ хариуцна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Улсын Их Хурлын бүрэлдэхүүн /6 дугаар зүйл/

Улсын Их Хурлын нийт гишүүн

- Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогдсон 76 гишүүнээс бүрдэх бөгөөд энэхүү бүрэлдэхүүнийг

Улсын Их Хурлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүн

- Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав буюу 57-оос доошгүй гишүүн сонгогдож, Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөсөн бол

Улсын Их Хурлын гишүүн, бүрэн эрх /7, 8 дугаар зүйл/

Д/д	Улсын Их Хурлын гишүүн	Гишүүний бүрэн эрх
1	Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ бол төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах;
2	Гишүүн “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн Төрийн сүлдэнд тангараг өргөнө.	Байнгын хороонд заавал харьяалагдах;
3	Гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.	Санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг өөрийн саналаар татаж авах;
4	Гишүүний бүрэн эрх Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.	Нэгдсэн хуралдаанд болон өөрийн харьяалагддаг Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох;
5	Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.	Төрийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, <i>улсын төсвийг хэлэлцэн батлахад Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7¹-д заасан хүрээнд санал гаргах;</i>
6		Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүнд орох, түүнээс гарах;
7		Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх;
8		Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хорооны ажлын хэсэгт хүсэлтээрээ, эсхүл томилсны дагуу орж ажиллах;
9		Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух, байр сууриа илэрхийлэх, санал гаргах, санал хураалгах;
10		Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх саналыг Байнгын хороонд оруулах;
11		Ерөнхий сайдыг огцруулах саналыг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын бусад гишүүнтэй хамтарч гаргах;
12		Нийтийн сонсгол зохион байгуулах санал гаргах;
13		Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж хариуг хуульд заасан хугацаанд авах, шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 38.3-т

¹ Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах

		зааснаас бусад асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах;
14		Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 38.3-т зааснаас бусад асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах, шаардлагагүй бол энэ тухай хариуг бичгээр өгөх;
15		Иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх;
16		Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах;
17		Бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүй уулзах, шаардлагатай асуудлаар тайлбар, мэдээлэл авах;
18		Онцгой чуулган зарласан бол зар хүлээлгүйгээр нэн даруй хүрэлцэн ирэх;
19		Төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг чанд хадгалж задруулахгүй байх;
20		Өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд товлосон хугацаанд хүрэлцэн ирж оролцох;
21		Улсын Их Хурлаас баталсан гишүүний ёс зүйн дүрэм, хуралдааны дэгийг чанд сахиж ажиллах;
22		Чуулганы хуралдаанд үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй байх;
23		Гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах;
24		Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах;
25		Хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэн зөв гаргах.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх /9 дүгээр зүйл/

1/Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ:

1.1.Гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;

1.2.Гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.

2/Эрх бүхий байгууллага гишүүнийг энэ хуулийн 9.1.1-д заасны дагуу баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор нэн даруй мэдэгдэнэ.

3/Улсын Их Хурал чуулганы үеэр энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан саналыг хүлээн авсан бол ажлын 5 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4/Улсын Их Хурал чуулганы чөлөө цагт энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан саналыг хүлээн авсан бол 24 цагийн дотор ээлжит бус чуулган зарлаж, чуулганы хуралдаан эхэлснээс хойш ажлын 5 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.


5/Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо, Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар нууцаар санал хурааж шийдвэрлэнэ. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхийг дэмжиж санал өгсөн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

6/Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг Улсын Их Хурал гаргасан бол баривчлагдсан гишүүнийг **1 цагийн дотор суллана**.


8/Энэ хуулийн 9.1.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг **хориглоно**.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох /10 дугаар зүйл/

1/Дараах тохиолдол гишүүний бүрэн эрх энэ хуулийн 7.3-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэл болно:



Улсын Их Хурал дахь олонх ба цөөнх /11 дүгээр зүйл/



2/Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн, ийнхүү зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2² дахь хэсэгт заасны дагуу олонхыг бүрдүүлнэ.

Улсын Их Хурлын даргыг сонгох /12 дугаар зүйл/

1/Улсын Их Хурал дахь **олонх болсон нам, эвсэл** Улсын Их Хурлын даргад **нэр дэвшүүлнэ**.

2/Аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол энэ хуулийн 11.2-т заасны дагуу олонхыг бүрдүүлсэн нам, эвсэл **зөвшилцөн** Улсын Их Хурлын даргад **нэр дэвшүүлнэ**.

3/Улсын Их Хурлын даргыг хэлэлцүүлэггүйгээр сонгох бөгөөд гишүүн саналаа илээр гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

4/Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол энэ хуулийн 12.1, 12.2-т заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

Улсын Их Хурлын даргын бүрэн эрх /14 дүгээр зүйл/

№	Эдлэх эрх
1	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах;
2	Ээлжит, ээлжит бус чуулган, хүндэтгэлийн хуралдаан зарлах, бэлтгэлийг хангах, нэгдсэн хуралдааныг даргалах;
3	Энэ хуулийн 14.3-т заасан Зөвлөлийн саналыг харгалзан чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох;
4	Ерөнхийлөгч, Засгийн газартай Улсын Их Хурлыг төлөөлөн харилцах;
5	Засгийн газрын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу тавих хяналтыг зохион байгуулах;
6	Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах;
7	Улсын Их Хурлын төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
8	Улсын Их Хурлыг дотоод, гадаадад төлөөлөх;
9	Улсын Их Хурлын гадаад харилцааны ажлыг зохион байгуулах;
10	Гишүүнийг төрийн дээд шагналд тодорхойлох;
11	Гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад дотоод, гадаад томилолт олгох, түүний журмыг баталж мөрдүүлэх;
12	Тамгын газрын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах;
13	Энэ хуулийн 14.1.5, 14.1.6-д заасан хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын удирдамжийг батлах, хэрэгжилтийг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
14	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;
15	Хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;
16	Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг харьяаллын дагуу Байнгын хороодод хуваарилах;

²Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.

17		Улсын Их Хурлын даргын зөвлөхийг томилох, чөлөөлөх шийдвэр гаргах;
18		Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор Ерөнхий сайдын гаргасан хүсэлтийг үндэслэн баталсан тов, дарааллыг харгалзахгүйгээр хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх шийдвэр гаргах;
19		Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;
20		Чуулганыг түр завсарлуулах болон хаах асуудлыг энэ хуулийн 14.3-т заасан Зөвлөлөөр хэлэлцүүлэн, захирамж гаргаж шийдвэрлэх;
21		Хуульд заасан бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр /16 дугаар зүйл/

1/Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь чуулган байна.

2/Чуулган нь нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хороо, түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ. Байнгын хороод хамтарсан хуралдаан хийж болно.


3/Улсын Их Хурлын чуулган анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой гэсэн хэлбэртэй байх бөгөөд Улсын Их Хурал хүндэтгэлийн хуралдаан хийж болно.

Анхдугаар чуулган /17 дугаар зүйл/

1/Анхдугаар чуулганыг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгч зарлигаар товлон зарлаж хуралдуулна.

2/Ерөнхийлөгч энэ хуулийн 17.1-д заасны дагуу зарлиг гаргахдаа анхдугаар чуулган нээх өдрийг Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэлтэй зөвшилцсөн байна.

3/Анхдугаар чуулганаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:



Ээлжит чуулган /18 дугаар зүйл/

1/Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 01-ний өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн **75-аас доошгүй ажлын өдөр** чуулна.

2/Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал урьдчилан хэлэлцэж тогтоол гаргах бөгөөд ээлжит чуулган эхлэхээс **7-оос доошгүй хоногийн өмнө** Улсын Их Хурлын дарга ээлжит чуулганаар **хэлэлцэх асуудлын дарааллыг** тогтоож захирамж гаргана.

Ээлжит бус чуулган /19 дүгээр зүйл/

1/Ээлжит чуулганы чөлөө цагт ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно.

2/Ээлжит бус чуулганыг Улсын Их Хурлын нийт гишүүний **гуравны нэгээс доошгүй** нь шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын **санаачилгаар** хуралдуулж болно.

3/Ээлжит бус чуулганаар зөвхөн Улсын Их Хурлын даргын **захирамжид заасан** болон **түүнтэй шууд холбоотой асуудлыг** хэлэлцэнэ.

Онцгой чуулган /20 дугаар зүйл/

1/Ээлжит чуулганы чөлөө цагт Ерөнхийлөгч **онц болон дайны байдал зарлавал** түүнээс хойш **72 цагийн дотор** Улсын Их Хурлын онцгой чуулган хуралдах бөгөөд гишүүд зар хүлээлгүйгээр хуралдаанд хүрэлцэн ирнэ.

2/Онц болон дайны байдал зарласан тухай Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор онцгой чуулганаар хэлэлцэж, зарлигийг батлах, эсхүл хүчингүй болгох шийдвэр гаргана.

3/Онцгой чуулган Ерөнхийлөгчийн зарлигийг баталсан бол уг зарлигийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлыг онцгой чуулганаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

4/Ээлжит чуулган хуралдаж байх үед онцгой нөхцөл үүсвэл тухайн чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг үл харгалзан **онц болон дайны байдал** зарлах асуудлыг хойшлуулахгүйгээр хэлэлцэн шийдвэрлэнэ.

5/Ээлжит чуулганы чөлөө цагт Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болсон үед Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлах тухай зарлиг гаргаагүй бол Улсын Их Хурлын гишүүдийн **дөрөвний нэгээс доошгүй** нь шаардсанаар Улсын Их Хурлын дарга онцгой чуулган зарлаж болно.


Байнгын хороо /23 дугаар зүйл/

1/Байнгын хороо **эрхлэх асуудлынхаа хүрээнд** хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах **чиг үүрэгтэйгээр** ажиллана.


2/Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна:

☐	Аюулгүй байдал, гадаад бодлогын	
☐	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн	
☐	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын	
☐	Нийгмийн бодлогын	
☐	Төрийн байгуулалтын	
☐	Төсвийн	
☐	Хууль зүйн	
☐	Эдийн засгийн	


Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ /24 дүгээр зүйл/




№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого
2		Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал
3		Хөдөөгийн хөгжлийн бодлого
4		Мал аж ахуйн бодлого
5		Малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах
6		Газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг
7		Улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар
8		Геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт
9		Агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал
10		Цаг уур, орчны хяналтын асуудал
11		Усны бодлого, нөөц, усны бохирдол
12		Хог хаягдал, дахин боловсруулалт
13		Байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал
14		Байгаль орчны судалгаа, хөгжил
15		Ан агнуур
16		Газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт
17		Газрын кадастр, зураглал



№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Төрийн байгуулалтын байнгын хороо	Үндсэн хуулийн шинэтгэлийн асуудал
2		Төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал
3		Засаг захиргааны шинэтгэл, төвлөрлийг сааруулах бодлого
4		Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, хот, тосгоны Зөвлөл, Захирагчийн сонгууль
5		Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, хот, тосгоны эрх зүйн үндэс
6		Төрийн алба
7		Төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал
8		Ард нийтийн санал асуулга
9		Төр, сүм хийдийн харилцаа
10		Хэвлэл мэдээллийн хараат бус байдал
11		Төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай харилцах
12		Гишүүний бүрэн эрхийн асуудал
13		Гишүүний ёс зүй
14		Гишүүний бүрэн эрхийн баталгаа
15		Улсын Их Хурлын болон гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт
16		Гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг
17		Чуулганы хуралдааны дэгийн асуудал
18		Бүсчилсэн хөгжлийн бодлого



№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Хууль зүйн байнгын хороо	Эрх зүйн бодлого
2		Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа
3		Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого
4		Улсын хил хамгаалалтын бодлого
5		Хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого
6		Шүүх эрх мэдэл
7		Прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэл
9		Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс
10		Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргаан, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа
11		Өршөөл үзүүлэх асуудал
12		Патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг
13		Цагаачлал, иргэний харьяалал
14		Архив
15		Эрх зүйн туслалцаа
16		Өмгөөлөл



№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Эдийн засгийн байнгын хороо	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл
2		Эдийн засгийн дотоод, гадаад бодлого
3		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал
4		Төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа
5		Даатгалын бодлого, энэ хуулийн 24.6.7-д зааснаас бусад үнэт цаасны тухай асууда
6		Төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого
7		Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого
8		Ашигт малтмалын суурь судалгаа, эрэл хайгуул, ашиглалтын бодлого

9		Газрын тос, байгалийн хийн асуудал
10		Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого
11		Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого
12		Төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого
13		Стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт
14		Албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт
15		Үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт
16		Барилга, хот байгуулалт
17		Түлш, эрчим хүч
18		Зам тээвэр, шуудан
19		Орон сууц, нийтийн аж ахуй
20		Аялал жуулчлалын хөгжлийн стратеги
21		Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил
22		Мэдээлэл, технологийн хөгжил
23		Харилцаа холбоо
24		Техник, технологийн шинэчлэл
25		Газрын эдийн засгийн үр ашгийн бодлого

28 дугаар зүйл.Дэд хороо

№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Дэд хороо харьяалагдах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцан санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд дараах асуудлыг эрхэлнэ:	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;
2		Ёс зүйн дэд хороо гишүүний ёс зүй, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийг сахиулах асуудлыг;
3		Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын асуудлыг;
4		Нутгийн удирдлагын дэд хороо нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн удирдлагын байгууллагын төлөвшил, хөгжил, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг;
5		Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо нь сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;
6		Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт , улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг;
7		Төсвийн зарлагын хяналтын дэд хороо нь улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;
8		Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх асуудлыг;
9		Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хурал, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;
10		Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН НЭГЭН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

35 дугаар зүйл. Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа

Улсын Их Хурлын
ээлжит сонгуулиар
сонгогдсон гишүүд
тангараг өргөснөөр
эхэлнэ.

4 жил

Дараагийн сонгуулиар
сонгогдсон гишүүд
тангараг өргөснөөр
дуусгавар болно.

2/Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой нөхцөл үүссэний улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол мөнхүү нөхцөл арилж шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл өмнөх Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

3/Улсын Их Хурлын ээлжит сонгууль зарласны дараа Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой нөхцөл үүсвэл Улсын Их Хурал ээлжит сонгууль зарласан шийдвэрээ цуцалж сонгуулийн үйл ажиллагааг зогсооно.

4/Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана.

5/Энэ хуулийн 35.4-т заасан хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийг товлон зарлаагүй бол дараагийн өдрийг Улсын Их Хурлын сонгууль товлон зарласан өдөрт тооцож, Сонгуулийн ерөнхий хороо ээлжит сонгуулийг зохион байгуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА, ТӨСӨВ, ХАВСРАН ГҮЙЦЭТГЭЖ БОЛОХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХОРИГЛОХ ЗҮЙЛ

Гишүүний бүрэн эрхийн баталгаа /40 дүгээр зүйл/

1/Гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, түүний албан тушаалтан дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2/Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Тамгын газар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, техник, зохион байгуулалт, ажиллах нөхцөлөөр хангана.

3/Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлж хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.

4/Гишүүн гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.

5/Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас, “Монгол Улсын Их Хурлын гишүүн” гэсэн тэмдэг, нэрийн хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Улсын Их Хурлын дарга захирамжаар батална.

6/Гишүүний харилцуур утас болон бусад тусгай хэрэглээний холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон шуудан, захидал харилцааны болон мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно.

7/Гишүүн, түүний унаа аливаа дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

8/Гишүүнээр ажилласан хугацааг нь мэргэжлээрээ ажилласан хугацаанд оруулан тооцно.

9/Гишүүний бүрэн эрх дуусгавар болсон бол түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн ажиллуулах, тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх 12 сарын хугацаанд гишүүний цалин, нэмэгдэлтэй тэнцэх нэг удаагийн тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, гишүүнээр сонгогдохоосоо өмнө оршин сууж байсан газартаа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн гишүүний замын зардал, ачаа, тээшийн хөлсийг авто тээврийн тарифаар тооцож олгоно.

10/Гишүүнийг эгүүлэн татсан бол түүнд энэ хуулийн 40.9-д заасан тэтгэмж бусад хангамж олгохыг хориглоно.

11/Онцгой чуулган зарласан тохиолдолд гишүүнийг чуулганд хүрэлцэн ирэх боломжийг Ерөнхийлөгч хангаж, шаардлагатай бол төрийн тусгай хамгаалалтад авна.

12/Гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний амь насны даатгалыг төр хариуцаж даатгалын хураамжийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

13/Гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд дараах баталгаагаар хангагдана:

13.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж болон авч байсан цалингийн зөрүүг олгох;

13.2.тахир дутуу болсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу тахир дутуугийн тэтгэвэр болон авч байсан цалингийн зөрүүг олгох;

13.3.хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал, түүнчлэн гишүүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтны хөлс олгох;

13.4.гишүүн магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаадад эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан бол зардлынх нь 70-аас доошгүй хувийг төр хариуцах.

14/Энэ хуулийн 40.13.2-т заасан цалингийн зөрүүг гишүүний бүрэн эрхийн хугацаатай адил хугацаагаар, энэ хуулийн 40.13.3-т заасан хөлсийг тусламж үйлчилгээ авсан хугацаанд олгоно.

15/Гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол 24 сарын, өвчний улмаас нас барсан бол 18 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.

16/Эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн гишүүний эрүүл мэндийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

17/Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар өөрийн төсөвтөө тусгасны үндсэн дээр гишүүн, түүний бие төлөөлөгч-туслахыг албан өрөө, тавилга, техник хэрэгслээр хангаж шаардлагатай бусад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Гишүүнд хориглох үйл ажиллагаа /43 дугаар зүйл/

№	Эрхлэх асуудлын хүрээ	
1	Гишүүнд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:	Ногдсон төсвийг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах;
2		Бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж бусдаас шан харамж авах;
3		Гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах;
4		Гишүүний нэр хүнд, эрх мэдлийг ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олох давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах;
5		Улсын Их Хурлын даргын зөвшөөрөлгүйгээр Засгийн газар, түүний байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний зардлаар гадаадад зорчих;

6	Бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, тээврийн хэрэгсэл, төрийн өмчийн бусад эд зүйлийг ашиг хонжоо олох зорилгоор, эсхүл сонгуулийн компанит ажилд ашиглах;
7	Хууль бус шийдвэр гаргуулахаар бусдад нөлөөлөх;
8	Гишүүний бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох, шахалт үзүүлэх;
9	Аливаа байгууллага, иргэнээс нэг сарын цалингийн хэмжээнээс дээш төгрөгийн үнэтэй бэлэг дурсгалын зүйлсийг хувиараа авах;
10	Бүрэн эрхийнхээ хугацаанд аж ахуй эрхлэх, аж ахуй эрхлэгчдийн холбоонд элсэх, аж ахуйн нэгжийн төлөөлөн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлд сонгогдох;
11	Бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Байнгын, дэд, түр хорооны болон нэгдсэн хуралдаанд, эсхүл хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж, доромжлох;
12	Бусдаар албаны чиг үүрэгт нь хамаарахгүй ажил, үүрэг гүйцэтгүүлэх, хууль бус болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш үйлдэл хийхийг шаардах;
13	Төрийн бус байгууллагын сонгуульт албан тушаал эрхлэх.

ДОЛДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ

Тамгын газар, түүний эрхлэх ажил /44 дүгээр зүйл/

1/Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна.

2/Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг Ерөнхий нарийн бичгийн даргын саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга батална.

3/Тамгын газрын зохион байгуулалтын нэгж нь газар, хэлтэс, алба, хүрээлэн, парламентын номын сан байна.

4/Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн бусад адилтгах албан тушаалаас зэрэглэл дээгүүр байхаар Улсын Их Хурал тогтооно.

5/Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.

6/Тамгын газрын албан хаагчийн мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

7/Албан үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн гэж үзвэл тухайн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх эрхтэй.

8/Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, түүнчлэн Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага өөрчлөгдсөн нь Тамгын газрын ажилтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

Ерөнхий нарийн бичгийн дарга /45 дугаар зүйл/

1/Ерөнхий нарийн бичгийн дарга нь Тамгын газрын дарга бөгөөд Улсын Их Хурлын дэгийн зөвлөх, төрийн захиргааны албан тушаалтан байна.

2/Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө. Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулах журам Ерөнхий нарийн бичгийн даргыг томилоход хамаарахгүй.

3/Ерөнхий нарийн бичгийн дарга намын харьяалалгүй байх бөгөөд уг албан тушаалд томилогдсон өдрөөс эхлэн намын гишүүнчлэлээс гарсанд тооцно.

4/Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаараа захирамж гаргана.

Улсын Их Хурлын даргын ажлын алба /47 дугаар зүйл/

1/Улсын Их Хурлын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна.

2/Улсын Их Хурлын даргын ажлын албаны орон тоог Улсын Их Хурлын дарга батална.

3/Улсын Их Хурлын даргын ажлын албаны ажилтан Улсын Их Хурлын даргад ажлаа шууд хариуцаж, Тамгын газарт харьяалагдана.

4/Улсын Их Хурлын даргын ажлын албаны ажилтныг Ерөнхий нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

---o0o---

**ТАВ. ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ДАГАЛДАХ ГАРАХ
ЭРХ ЗҮЙН АКТЫН ТУХАЙ**

№	Журам, дүрмийн нэр	Батлах субъект	Хуулийн заалт
1	Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам	Улсын Их Хурал	4 дүгээр зүйлийн 4.5
2	Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллах зөвлөлийн ажиллах журам	Улсын Их Хурлын дарга	14 дүгээр зүйлийн 14.5
3	Улсын Их Хурлын чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх журам	Улсын Их Хурлын дарга	22 дугаар зүйлийн 22.19
4	Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудас, тэмдгийн загвар, хэрэглэх журам	Улсын Их Хурлын дарга	40 дүгээр зүйлийн 40.5
5	Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн чуулганы ажиллагаанд оролцох журам	Ерөнхий сайдын саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга	42 дугаар зүйлийн 42.3
6	Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм	Ерөнхий нарийн бичгийн даргын саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга	44 дүгээр зүйлийн 44.2